



**МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН
ТУШААЛ**

2016 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/11

Улаанбаатар хот

**Дотоод аудитын хорооны бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай**

“Төсвийн тухай хууль”-ийн 69 дүгээр зүйлийн 1, Засгийн газрын 2012 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 4.3, 4.4, Сангийн сайдын 2013 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийн 2.2, 2.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн Тушаах нь:

1.Байгаль Орчин, Ногоон Хөгжил, Аялал Жуулчлалын сайдын дэргэдэх Дотоод аудитын хороог дараах бүрэлдэхүүнтэй баталсугай. Үүнд:

| | | |
|-----------------------|---------------|--|
| Хорооны дарга: | Н.Батцэрэг | Сайд |
| Нарийн бичгийн дарга: | Б.Нансалмаа | Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн |
| Гишүүд: | Ц.Цэнгэл | Төрийн нарийн бичгийн дарга |
| | Т.Булган | Ногоон хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлтийн газрын дарга |
| | М.Чаминцэцэг | Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч |
| | Д.Цэцэгсүрэн | Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч |
| | Б.Батбаяр | Байгаль Орчны Иргэний Зөвлөлийн удирдах зөвлөлийн гишүүн |
| | Л.Энх-Амгалан | Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институтийн дэд Ерөнхийлөгч |

2. Дотоод аудитын хорооны хуралдааныг шаардлагатай тухай бүрд нь шуурхай зохион байгуулж, хуралдааны шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга / Д.Цэцэгсүрэн /-д үүрэг болгосугай.

САЙД  Н.БАТЦЭРЭГ



011423